

# Э-Сонин

37 дахь дугаар

**Засгийн газрын үнэт  
цаасны танилцуулга**

**11-р сарын үйл  
явдлын хураангүй**




## ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААС /ЗГҮЦ/ ГЭЖ ЮУ ВЭ?

ЗГҮЦ нь хувь хүн, аж ахуйн нэгжид зориулсан хөрөнгө оруулалтын хэрэгсэл бөгөөд нэгж бүр нь **100,000** /нэг зуун мянга/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй, тогтсон хугацаанд хүү төлдөг /тогтмол хугацаанд эсхүл үнэт цаасны хугацааны эцэст/ Засгийн газрын өрийн бичиг юм.



## ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ ДАВУУ ТАЛ, АЧ ХОЛБОГДОЛ




**ТАТВАР, ИНФЛЯЦИЙН ДАРААХ ӨГӨӨЖИЙН ХЭМЖЭЭ**

Банк	Зарласан хүү / жил/	10%-ийн албан татвар ноогдсоны дараах өгөөж /(1)*(1-10%)/	Инцляцийн 11% хасагдсан өгөөж, /(2)-11%/
	(1)	(2)	(3)
ХХБ	10.2%	9.2%	-1.8%
Хас банк	10.5%	9.5%	-1.6%
Капитал банк	11.0%	9.9%	-1.1%
Голомт банк	11.4%	10.3%	-0.7%
Хаан банк	12.1%	10.9%	-0.1%
Төрийн банк	12.4%	11.0%	0.0%
<b>ЗГҮЦ</b>	<b>14.7%</b>	<b>ЗГҮЦ-ны хүүд татвар тооцохгүй</b>	<b>3.6%</b>

**ИЖИЛ ХУГАЦААТАЙ ХАДГАЛАМЖИЙН ХҮҮТЭЙ ХАРЬЦУУЛСАН  
ЗГҮЦ-НЫ ХҮҮГИЙН ХЭМЖЭЭ**

<b>ЖИЛИЙН ХҮҮГИЙН ХЭМЖЭЭ (ХУВИАР)</b>			
	<b>3сар</b>	<b>6 сар</b>	<b>12 сар</b>
ХХБ	10.2%	13.2%	15.0%
Хас банк	10.2%	13.0%	15.0%
Капитал банк	11.2%	13.2%	15.5%
Голомт банк	10.8%	13.44%	15.2%
Кредит банк	12.0%	13.5%	15.3%
Хаан банк	10.3%	13.3%	15.1%
Төрийн банк	10.3%	13.3%	15.2%
<b>ЗГҮЦ</b>	<b>14.0%</b>	<b>14.5%</b>	<b>16.2%</b>

### ЗГҮЦ-НЫ АРИЛЖААНЫ СХЕМ




1. ЗГҮЦ худалдан авах төлбөрийг арилжааны банканд өөрийн нэр дээрх дансанд байршуулна.
2. Үнэт Цаасны Компаниар дамжуулан ЗГҮЦ худалдан авах захиалгаа өгнө
3. ҮЦК нь иргэд болон ААН үүдээс авсан бонд худалдан авах захиалгыг МХБ-ийн системд шивэх.

### ЗГҮЦ-НЫ ӨГӨӨЖИЙН МЭДЭЭЛЭЛ

2014 оны 11 дүгээр сараас хойш Засгийн газрын үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа 57 удаа явагдаж нийт 5,410,274 ширхэг үнэт цаасыг 513.5 тэрбум төгрөгөөр арилжаад байна. Үүнээс 319.4 тэрбум төгрөгийн ЗГҮЦ-ны хүүгийн болон үндсэн төлбөрийн эргэн төлөлт хийгдэж, 11.3 тэрбум төгрөгийн өгөөжийг хөрөнгө оруулагчид хүртсэн байна.

Харин үлдсэн 194.1 тэрбум төгрөгийн ЗГҮЦ-ны хүүгийн болон үндсэн төлбөр хийгдээгүй ба 18.7 тэрбум төгрөгийн өгөөжийг хөрөнгө оруулагчид авахаар хүлээж байна.

	Арилжсан ЗГҮЦ-ны үнийн дүн /тэрбум төгрөг/	Арилжсан ЗГҮЦ-ны өгөөжийн хэмжээ /тэрбум төгрөг/
Олгогдсон өгөөж	319.4	11.3
Хүлээгдэж буй өгөөж	194.1	18.7
<b>НИЙТ</b>	<b>513.5</b>	<b>30.0</b>



## ЗГҮЦ-НЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЭЛ

### АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛ

2014 оны 11 дүгээр сараас хойш Засгийн газрын үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа 57 удаа явагдаж нийт 5,410,274 ширхэг үнэт цаасыг 513.5 тэрбум төгрөгөөр арилжаад байна.

Энэ онд анхдагч зах зээл дээр нийт 5,034,735 ширхэг ЗГҮЦ-ыг **486.6 тэрбум** төгрөгөөр арилжсанаас:

- 12 долоо хоногтой үнэт цаас 66%
- 28 долоо хоногтой үнэт цаас 18%
- 52 долоо хоногтой үнэт цаас нийт арилжааны 16%-ийг тус тус эзэлж байна.



### ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛ

- ЗГҮЦ-ыг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нь анхдагч зах зээлээс гадна хоёрдогч зах зээл дээрээс хүссэн үедээ ЗГҮЦ худалдан авах болон эргүүлэн худалдан боломжтой.
- ЗГҮЦ нь анхдагч зах зээлд гарсан хүүгийн төвшинөөс хамааран өөр өөр өгөөжтэй байдаг тул анхдагч зах зээл болон хоёрдогч зах зээл дээр арилжигдаж буй ЗГҮЦ-ны өгөөжийг харьцуулан тооцон үзэж хөрөнгө оруулалт хийх нь зүйтэй.
- 2015 оны 1 дүгээр сараас ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаа явагдаж эхэлсэн бөгөөд 12, 28 болон 52 долоо хоногтой үнэт цаасууд арилжигдаж нийт **3.4** тэрбум төгрөгний гүйлгээ хийгдсэн байна.



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ  
АРИЛЖААНЫ ЭРГЭН ТӨЛӨЛТ**

2015 оны 1 дүгээр сарын 1-нээс өнөөдрийг хүртэлх хугацаанд /2015.11.30/ МХБ-ийн анхдагч зах зээл дээр 3 сар, 6 сар болон 1 жилийн хугацаатай Засгийн газрын үнэт цаасыг нийт **486.7** тэрбум төгрөөр арилжсан.

Үүнээс тус үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөр болох **283.5** тэрбум төгрөгийг үнэт цаас гаргагч буюу Засгийн газраас хөрөнгө оруулагчидад төлсөн байна.


Харин **203.2** тэрбум төгрөгийн үндсэн болон хүүгийн төлбөр хийгдэхээр хүлээгдэж байна. Дараах хүснэгтэд дэлгэрэнгүй мэдээллийг харуулав.

Д/хоног	ширхэг	Арилжигдсан үнийн дүн	Эргэн төлөгдсөн	Эргэн төлөгдөөгүй
12	3,310,500	320,165,982,779.00	281,402,482,779.00	38,763,500,000.00
28	972,692	90,327,932,314.00	2,092,532,314.00	88,235,400,000.00
52	850,337	76,064,800,000.00	-	76,064,800,000.00
156	1,186	118,600,000.00	-	-
260	20	2,000,000.00	-	-





## ЗГҮЦ-НЫ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНЫ ТОЙМ







### 11-Р САРЫН ЗГҮЦ-НЫ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЭЛ

Засгийн газрын үнэт цаасны /нэгжийн үнэ 100,000 төгрөг/ захиалгыг долоо хоног бүрийн Лхагва гарагаас дараа долоо хоногийн Мягмар гараг хүртэл авч, арилжааг зохион байгуулж байна. Арваннэгдүгээр сард тус үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг 4 удаа зохион байгуулж нийт **37.4** тэрбум төгрөгийн богино болон урт хугацаат ГЗҮЦ-ыг арилжаалсан байна.

Өдөр	Хугацаа /7 хоног/	Зарагдсан тоо хэмжээ /ш/	Хямдруулсан үнэ	Хүүгийн хэмжээ	Үнийн дүн /төгрөг/
2015.11.03	12	100,000	96,907	13.871%	9,690,700,000.00
2015.11.10	28	100,000	93,068	13.871%	9,306,800,000.00
2015.11.17	52	100,000	87,077	14.882%	8,707,700,000.00
2015.11.24	12	100,000	96,922	13.800%	9,692,200,000.00
2015.11.24	156	679	-	15.750%	67,900,000.00
<b>НИЙТ</b>		<b>400,679</b>			<b>37,465,300,000.00</b>

### 11-Р САРЫН ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЭЛ



Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа нийт 19 удаа хэлцэл хийж 4,230 ширхэг ЗГҮЦ-ыг хоёрдогч зах зээл дээр **412.6** сая төгрөгөөр арилжаалсан байна.

Он сар	Арилжсан ширхэг	Үнийн дүн	Он сар	Арилжсан ширхэг	Үнийн дүн
2015.11.04	400	40,020,000.00	2015.11.06	133	12,444,810.00
2015.11.05	10	987,800.00	2015.11.06	200	18,714,000.00
2015.11.05	10	977,100.00	2015.11.16	1,000	99,690,000.00
2015.11.05	10	945,800.00	2015.11.18	10	950,000.00
2015.11.05	3	263,520.00	2015.11.18	1,047	99,967,560.00
2015.11.05	15	1,395,600.00	2015.11.27	22	2,137,740.00
2015.11.05	100	9,779,000.00	2015.11.27	10	1,000,000.00
2015.11.06	10	986,200.00	2015.11.27	10	1,000,000.00
2015.11.06	200	19,568,000.00	2015.11.27	10	1,000,000.00
2015.11.06	1,030	100,764,900.00	<b>НИЙТ</b>	<b>4,230</b>	<b>412,592,030.00</b>

## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО, МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ШИЙДВЭРҮҮД

### “ХААБЗ” ХК ОНООСОН НЭРЭЭ “ХҮННҮ МЕНЕЖМЕНТ” ХК БОЛГОН ӨӨРЧИЛЛӨӨ

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйл, “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 20.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2015 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 317 дугаар тушаалаар “ХААБЗ” ХК-ийн оноосон нэрийг Хорооны үнэт цаасны бүртгэлд “Хүннү менежмент” ХК болгон өөрчиллөө.

### “БИШРЭЛТ ИНДАСТРИЭЛ” ХК-ИЙН ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛЭЭС ХАСЛАА

Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 310 дугаар тоот тогтоол, Компанийн тухай хуулийн 83.1 дүгээр зүйл, “Бишрэлт индастриэл” ХК-ийн 2015 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн 30/2015 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг үндэслэж 2015 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр “Бишрэлт Индастриэл” (MSE:ННС) ХК-ны гаргасан нийт 700,523 ширхэг хувьцааг Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлээс хаслаа.

### “НОВЕЛ ИНВЕСМЕНТ ҮЦК” ХХК ИТГЭМЖЛЭГДСЭН ДИЛЕРИЙН БАТЛАМЖ АВЛАА

Монголын Хөрөнгийн биржээс 2015 оны 2 дугаар сараас эхлэн олон улсын хөрөнгийн зах зээлийн стандарт дэд бүтэц болох “Market Makers” буюу “Итгэмжлэгдсэн дилер”-ийн тогтолцоог зах зээлд нэвтрүүлсэн билээ.

2015 оны 11 дүгээр сар 9-ний өдөр Монголын хөрөнгийн биржийн гишүүн үнэт цаасны “Новел инвестмент ҮЦК” ХХК “Итгэмжлэгдсэн дилер”-ийн батламж авч, гэрээнд гарын үсэг зурлаа.

Өнгөрсөн долоо хоногт Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээл дээр 2112 ширхэг үнэт цаас 206.8 сая төгрөгөөр арилжигдсанаас “Новел инвестмент ҮЦК” 98%-ийг гүйцэтгэсэн байна.





ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЛЭГ ОЛГОХ  
ЭЭЛЖИТ СУРГАЛТ ӨНДӨРЛӨЛӨӨ

ТӨГСӨЛТИЙН БАЯР



Монголын Хөрөнгийн Биржийн “Үнэт цаасны зах зээлийн мэдлэг олгох” анхан шатны ээлжит сургалт 2015 оны 11 дүгээр сарын 23-ноос 11 дүгээр сарын 27-ны хооронд явагдаж дууслаа.

Сургалтыг онол-практикийг хослуулан Брокер, дилерийн компанийн үйл ажиллагаатай танилцуулах, арилжаанд оролцуулах хэлбэрээр явуулсан нь суралцагчдын сонирхолд ихэд нийцсэн сургалт боллоо.

Сургалтад цаашид хамрагдах сонирхолтой иргэд, оюутан залуусын тоо өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа нь нийгмийн эрэлт хэрэгцээ их байгаагийн илрэл юм. Иймд бид дараагийн сургалтыг 2015 оны 12 дугаар сарын 07-ны өдрөөс явуулахаар төлөвлөж байна.

*Үнэт цаасны зах зээлийн боловсролоо дээшлүүлэх үйлсэд тань амжилт хүсье*





2015 оны 11 дүгээр сар

## Арилжааны товч мэдээ

Арилжигдсан ширхэг	1,575,943
Нийт үнийн дүн /төг/	38,205,401,678.50
Хэлцлийн тоо	824
Арилжигдсан үнэт цаасны тоо	69
Зах зээлийн үнэлгээ /төг/	1,255,555,732,833


## ТОП-20 индекс

Хаалт	12,489.58
Өөрчлөлт /%/	-5.46

## MSE ALL индекс

Хаалт	887.99
Өөрчлөлт /%/	-5.16

## ТОП 20 ИНДЕКС



## Идэвхтэй арилжигдсан үнэт цаас:

Тоо ширхэгээр:				Үнийн дүнгээр:			
№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	№	Симбол	Үнэт цаасны нэр	Үнийн дүн
1	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	730,242	1	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	76,988,237
2	ETR	Э-ТРАНС ЛОЖИСТИКС	170,099	2	SUU	СҮҮ	45,980,800
3	TCK	ТАЛХ ЧИХЭР	142,650	3	UID	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	25,316,181
4	UID	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	39,861	4	TCK	ТАЛХ ЧИХЭР	21,881,370
5	NBO	ХАЙ БИ ОЙЛ	18,000	5	NEH	ДАРХАН НЭХИЙ	21,665,800

## Хамгийн их өсөлттэй үнэт цаас:

№	Симбол	Үнэт цаасны нэр	Хаалтын ханш	Ханшийн өөрчлөлт	
					%
1	GHC	ГАН ХИЙЦ	19,130.00		19.56
2	UNS	УЛААНСАН	1,592.00		17.93
3	ONH	ӨНДӨРХААН	10,830.00		15.03
4	DZG	ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ	23,000.00		15.00
5	TEX	ТЕХНИК ИМПОРТ	1,605.00		14.97

## Хамгийн их бууралттай үнэт цаас:

№	Симбол	Үнэт цаасны нэр	Хаалтын ханш	Ханшийн өөрчлөлт	
					%
1	BDL	МОГОЙН ГОЛ	6,000.00		-22.63
2	BEU	БЭРХ УУЛ	2,210.00		-21.07
3	MIE	МАТЕРИАЛИМПЕКС	7,900.00		-21.00
4	SHG	ШАРЫН ГОЛ	4,000.00		-19.92
5	NKT	НАКО ТҮЛШ	288.97		-15.01

## Засгийн газрын үнэт цаас: /анхдагч зах зээл/

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн	Үнэ	Хугацаа /долоо хоног/	Хүүгийн хэмжээ %
1	ЗГХБ-Б-12-336	100,000	9,690,700,000	96,907	12	13.871
2	ЗГХБ-Б-28-337	100,000	9,306,800,000	93,068	28	13.871
3	ЗГХБ-Б-52-338	100,000	8,707,700,000	87,077	52	14.882
4	ЗГХБ-Б-12-339	100,000	9,692,200,000	96,922	12	13.800
5	ЗГЭБ-У-156-340	679	67,900,000	100,000	156	15.750

## Засгийн газрын үнэт цаас: /хоёрдогч зах зээл/

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн	Дээд ханш	Доод ханш	Сүүлчийн ханш
1	ZGEB-BD-10/11/15-A0002-16.25	400	40,020,000	100,050	100,050	100,050
2	ZGEB-BL-24/11/15-A0032-0	10	987,800	98,780	98,780	98,780
3	ZGEB-BL-22/12/15-A0038-0	10	977,100	97,710	97,710	97,710
4	ZGEB-BL-22/03/16-A0053-0	10	945,800	94,580	94,580	94,580
5	ZGEB-BL-13/09/16-A0055-0	3	263,520	87,840	87,840	87,840
6	ZGEB-BL-12/04/16-A0059-0	15	1,395,600	93,040	93,040	93,040
7	ZGEB-BL-05/01/16-A0063-0	100	9,779,000	97,790	97,790	97,790
8	ZGEB-BL-22/12/15-A0038-0	10	986,200	98,620	98,620	98,620
9	ZGEB-BL-05/01/16-A0063-0	200	19,568,000	97,840	97,840	97,840
10	ZGEB-BL-05/01/16-A0063-0	1,030	100,764,900	97,830	97,830	97,830
11	ZGEB-BL-03/05/16-A0065-0	133	12,444,810	93,570	93,570	93,570
12	ZGEB-BL-03/05/16-A0065-0	200	18,714,000	93,570	93,570	93,570
13	ZGEB-BL-24/11/15-A0051-0	1,000	99,690,000	99,690	99,690	99,690
14	ZGEB-BL-15/11/16-A0075-0	10	950,000	95,000	95,000	95,000
15	ZGEB-BL-22/03/16-A0053-0	1,047	99,967,560	95,480	95,480	95,480
16	ZGEB-BL-09/02/16-A0045-0	22	2,137,740	97,170	97,170	97,170
17	ZGEB-BD-01/03/16-A0017-16.625	10	1,000,000	100,000	100,000	100,000
18	ZGEB-BD-30/03/16-A0024-16.375	10	1,000,000	100,000	100,000	100,000
19	ZGEB-BD-28/04/16-A0029-16	10	1,000,000	100,000	100,000	100,000